

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Баянхонгор аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БНА-2026/010/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2026 оны 02 дүгээр сарын 13</p> <p><b>2026</b></p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат</p> <p>Утас: 70442584      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: М.Алтантуяа</p> <p>Утас: 70442424      Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитор: Н.Бүнчинсүрэн</p> <p>Утас: 99049866      Цахим хаяг: bunchinsuren@audit.gov.mn</p>
---	--

**НЭГ.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2026.02.23 № 2/26  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тус байгууллагын дасгалжуулагч нарт тамирчдаа тэмцээн, уралдаанд авч явахад нь 19,881.0 мянган төгрөгийн урьдчилгаа олгосон боловч мөнгөн кассын журмын дагуу нярав кассын тайлан бэлтгэн гаргаагүй байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**8426050075**

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-  
албан тоот.docx

### **Бусад асуудын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 61 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 89.4 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР / Б.МӨНХБАТ



**ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	3,309,683.42	13,673,713.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.42	0.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	10,364,030.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	3,309,683.00	3,309,683.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	3,309,683.00	3,309,683.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	98,234,700.00	103,987,722.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	98,234,700.00	103,987,722.00
35410	Бичиг хэргийн материал	2,907,200.00	816,500.00
35420	Аж ахуйн материал	27,212,800.00	23,435,150.00
35430	Сэлбэг хэрэгсэл	405,000.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	0.00
35450	Барилгын засварын материал	8,814,500.00	720,600.00
35470	Бусад хангамжийн материал	58,895,200.00	79,015,472.00
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>101,544,383.42</b>	<b>117,661,435.00</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	7,782,689,207.32	20,294,781,442.76
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	6,336,011,207.32	18,848,403,442.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,212,510,935.49	19,453,099,635.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	-921,952,251.52	-1,094,503,119.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	112,100,000.00	112,100,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-51,258,333.46	-72,558,333.46
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	130,209,316.82	345,610,726.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	-64,578,447.54	-112,403,724.45
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	192,906,487.00	342,754,760.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	-84,036,499.47	-125,836,502.47
39214	Бусад үндсэн хөрөнгө	140,000.00	140,000.00
39216	Дуусаагүй барилга, байгууламж	809,970,000.00	0.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	1,446,678,000.00	1,446,378,000.00
39301	Програм хангамж	2,160,000.00	2,160,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,560,000.00	-1,860,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,446,078,000.00	1,446,078,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7,782,689,207.32</b>	<b>20,294,781,442.76</b>
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>7,884,233,590.74</b>	<b>20,412,442,877.76</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.00	5,873,750.01
<b>413</b>	<b>Өглөг</b>	0.00	5,873,750.01
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	54,613.01
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	0.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	0.00	5,819,137.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	5,116,637.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	702,500.00
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>5,873,750.01</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	7,884,233,590.74	20,406,569,127.75
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,901,310,973.58	1,901,310,973.58
51101	Өмч: - төрийн	1,901,310,973.58	1,901,310,973.58
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	4,703,346,877.79	17,385,028,741.16
51210	Өмнөх үеийн үр дүн	4,787,540,587.72	4,052,723,204.15
51220	Тайлант үеийн үр дүн	-84,193,709.93	13,332,305,537.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,279,575,739.37	1,120,229,413.01
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>7,884,233,590.74</b>	<b>20,406,569,127.75</b>
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>7,884,233,590.74</b>	<b>20,412,442,877.76</b>

Баянхонгор аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,360,549,847.50</b>	<b>17,589,918,517.35</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,358,299,847.50</b>	<b>3,933,953,525.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,136,379,100.00	1,237,357,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,136,379,100.00	1,237,357,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>196,973,847.50</b>	<b>523,241,825.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	75,622,337.50	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,076,600.00	514,314,825.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	111,274,910.00	8,927,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>2,024,946,900.00</b>	<b>2,173,353,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,024,946,900.00	2,173,353,800.00
<b>12</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО</b>	<b>2,250,000.00</b>	<b>13,655,964,992.35</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,250,000.00</b>	<b>13,655,964,992.35</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	26,501,438.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		26,501,438.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	2,250,000.00	13,582,125,476.35
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	47,338,078.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,444,743,557.43</b>	<b>4,257,612,980.34</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,184,164,211.31</b>	<b>4,065,912,615.98</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,040,861,992.39</b>	<b>1,136,452,707.40</b>
210101	Үндсэн цалин	516,237,837.06	632,279,966.69
210102	Нэмэгдэл	348,225,591.07	324,920,065.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58,341,501.94	121,385,103.00
210104	Урамшуулал	99,335,737.00	57,867,572.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,721,325.32	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>116,333,748.70</b>	<b>135,169,500.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	79,137,949.93	91,920,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,299,099.69	10,814,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,649,299.35	5,407,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,649,299.95	5,407,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,598,099.78	21,620,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,604,533,711.62</b>	<b>1,827,166,199.67</b>
210301	Гэрэл, цахилгаан	120,567,794.49	149,761,660.39
210302	Түлш, халаалт	1,425,323,047.13	1,628,622,819.28
210303	Цэвэр, бохир ус	58,642,870.00	48,781,720.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>30,598,750.25</b>	<b>80,122,036.00</b>
210401	Бичиг хэрэг	8,953,500.00	23,409,950.00
210402	Тээвэр, шатахуун	4,565,438.00	37,956,898.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,799,012.25	3,615,538.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,080,800.00	14,839,650.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>2,338,450.00</b>	<b>0.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	131,350.00	0.00
210502	Хоол, хүнс	2,207,100.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,247,950.00</b>	<b>65,444,724.00</b>
210604	Урсгал засвар	7,247,950.00	65,444,724.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,417,600.00</b>	<b>850,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,417,600.00	850,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,790,311.00</b>	<b>216,870,632.00</b>

**Баянхонгор аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,181,400.00	210,263,295.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	995,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	238,500.00	429,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	21,600.00	66,000.00
210807	Газрын төлбөр	4,348,811.00	5,116,637.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>370,041,697.35</b>	<b>603,836,816.91</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	110,982,425.00	289,418,576.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	250,000.00	855,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	258,809,272.35	313,563,240.91
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>260,579,346.12</b>	<b>191,700,364.36</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>96,674,339.00</b>	<b>25,883,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,514,139.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,539,500.00	15,383,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	44,620,700.00	10,500,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>34,662,618.29</b>	<b>156,762,978.03</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,431,808.29	155,835,978.03
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,230,810.00	927,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>129,242,388.83</b>	<b>9,054,386.33</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	129,242,388.83	9,054,386.33
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,444,743,557.43</b>	<b>4,257,612,980.34</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-84,193,709.93</b>	<b>13,332,305,537.01</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-84,193,709.93</b>	<b>13,332,305,537.01</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>3,358,299,847.50</b>	<b>3,960,454,963.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,358,299,847.50</b>	<b>3,933,953,525.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,136,379,100.00</b>	<b>1,237,357,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,136,379,100.00	1,237,357,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>196,973,847.50</b>	<b>523,241,825.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	75,622,337.50	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,076,600.00	514,314,825.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	111,274,910.00	8,927,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>2,024,946,900.00</b>	<b>2,173,353,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,024,946,900.00	2,173,353,800.00
<b>12</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>26,501,438.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>0.00</b>	<b>26,501,438.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>0.00</b>	<b>26,501,438.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		26,501,438.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)</b>	<b>3,215,104,847.50</b>	<b>3,906,954,963.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,215,104,847.50</b>	<b>3,906,954,963.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,950,618,701.38</b>	<b>3,704,890,568.64</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,041,002,254.81</b>	<b>1,136,398,093.97</b>
210101	Үндсэн цалин	573,903,664.48	632,225,353.26
210102	Нэмэгдэл	295,450,026.07	324,920,065.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	53,591,501.94	121,385,103.00
210104	Урамшуулал	99,335,737.00	57,867,572.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,721,325.32	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>116,333,748.70</b>	<b>135,169,500.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	79,137,949.93	91,920,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,299,099.69	10,814,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,649,299.35	5,407,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,649,299.95	5,407,000.00

**Баянхонгор аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210205	Эрүүл мэндийн даатгал	18,598,099.78	21,620,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,604,533,711.62</b>	<b>1,827,166,199.67</b>
210301	Гэрэл, цахилгаан	120,567,794.49	149,761,660.39
210302	Түлш, халаалт	1,425,323,047.13	1,628,622,819.28
210303	Цэвэр, бохир ус	58,642,870.00	48,781,720.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,075,462.25</b>	<b>8,098,043.00</b>
210401	Бичиг хэрэг	1,213,000.00	1,800,000.00
210402	Тээвэр, шатахуун	400,000.00	1,734,505.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,799,012.25	3,615,538.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,463,450.00	648,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>23,585,000.00</b>	<b>50,496,614.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	585,000.00	0.00
210604	Урсгал засвар	23,000,000.00	50,496,614.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,417,600.00</b>	<b>850,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,417,600.00	850,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>28,332,411.00</b>	<b>408,984,981.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,723,500.00	407,494,281.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	995,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	238,500.00	429,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	21,600.00	66,000.00
210807	Газрын төлбөр	4,348,811.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>125,338,513.00</b>	<b>137,727,137.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	123,288,513.00	136,522,137.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,050,000.00	1,205,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>264,486,146.12</b>	<b>202,064,394.36</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>100,581,139.00</b>	<b>25,883,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,514,139.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,539,500.00	15,383,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	48,527,500.00	10,500,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>34,662,618.29</b>	<b>167,127,008.03</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,431,808.29	155,835,978.03
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,230,810.00	11,291,030.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>129,242,388.83</b>	<b>9,054,386.33</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	129,242,388.83	9,054,386.33
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>143,195,000.00</u></b>	<b><u>53,500,000.00</u></b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>143,195,000.00</b>	<b>53,500,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>143,195,000.00</b>	<b>53,500,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	143,195,000.00	53,500,000.00
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>143,195,000.00</b>	<b>53,500,000.00</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-143,195,000.00</u></b>	<b><u>-53,500,000.00</u></b>
<b>14</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>15</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	1,901,310,973.58	1,279,575,739.37	4,787,540,587.72	7,968,427,300.67
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,901,310,973.58</b>	<b>1,279,575,739.37</b>	<b>4,787,540,587.72</b>	<b>7,968,427,300.67</b>

**Баянхонгор аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-84,193,709.93	-84,193,709.93
C08	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,901,310,973.58</b>	<b>1,279,575,739.37</b>	<b>4,703,346,877.79</b>	7,884,233,590.74
D01	<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,901,310,973.58</b>	<b>1,279,575,739.37</b>	<b>4,703,346,877.79</b>	7,884,233,590.74
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-650,623,673.64	-650,623,673.64
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,901,310,973.58</b>	<b>1,279,575,739.37</b>	<b>4,052,723,204.15</b>	7,233,609,917.10
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	-159,346,326.36	0.00	-159,346,326.36
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	13,332,305,537.01	13,332,305,537.01
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,901,310,973.58</b>	<b>1,120,229,413.01</b>	<b>17,385,028,741.16</b>	20,406,569,127.75

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,562,481,000.00</b>	<b>3,272,322,773.64</b>	<b>290,158,226.36</b>	<b>91.9%</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,356,670,100.00	1,087,025,921.97	269,644,178.03	80.1%
Улсын төсвөөс санхүүжих	1,356,670,100.00	1,087,025,921.97	269,644,178.03	80.1%
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,197,810,900.00	2,164,299,413.67	33,511,486.33	98.5%
Орон нутгийн төсвөөс	2,197,810,900.00	2,164,299,413.67	33,511,486.33	98.5%
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	8,000,000.00	20,997,438.00	(12,997,438.00)	262.5%
Үндсэн үйл ажиллагааны орлого	8,000,000.00	20,997,438.00	(12,997,438.00)	262.5%
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>3,562,481,000.00</b>	<b>3,272,322,773.64</b>	<b>290,158,226.36</b>	<b>91.9%</b>
<b>Ажиллагчидтай холбогдсон зардал</b>	<b>1,411,112,000.00</b>	<b>1,251,786,079.97</b>	<b>159,325,920.03</b>	<b>88.7%</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,253,363,700.00	1,116,616,579.97	136,747,120.03	89.1%
Үндсэн цалин	690,715,000.00	632,225,353.26	58,489,646.74	91.5%
Нэмэгдэл	397,198,200.00	305,138,551.71	92,059,648.29	76.8%
Унаа хоолны хөнгөлөлт	95,500,100.00	121,385,103.00	(25,885,003.00)	127.1%
Урамшуулал	69,950,400.00	57,867,572.00	12,082,828.00	82.7%
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	157,748,300.00	135,169,500.00	22,578,800.00	85.7%
Тэтгэврийн даатгал	107,268,500.00	91,920,800.00	15,347,700.00	85.7%

Баянхонгор аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан				
Тэтгэмжийн даатгал	12,619,900.00	10,814,400.00	1,805,500.00	85.7%
ҮОМШӨ-ний даатгал	6,309,900.00	5,407,000.00	902,900.00	85.7%
Ажилгүйдлийн даатгал	6,309,900.00	5,407,000.00	902,900.00	85.7%
Эрүүл мэндийн даатгал	25,240,100.00	21,620,300.00	3,619,800.00	85.7%
<b>Бараа үйлчилгээний урсгал зардал</b>	<b>2,034,592,500.00</b>	<b>2,004,373,693.67</b>	<b>30,218,806.33</b>	<b>98.5%</b>
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,838,682,400.00</b>	<b>1,827,166,199.67</b>	<b>11,516,200.33</b>	<b>99.4%</b>
Гэрэл, цахилгаан	160,000,000.00	149,761,660.39	10,238,339.61	93.6%
Түлш, халаалт	1,608,682,400.00	1,628,622,819.28	(19,940,419.28)	101.2%
Цэвэр, бохир ус	70,000,000.00	48,781,720.00	21,218,280.00	69.7%
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,507,200.00</b>	<b>8,098,043.00</b>	<b>4,409,157.00</b>	<b>64.7%</b>
Бичиг хэрэг	1,440,000.00	1,800,000.00	(360,000.00)	125.0%
Тээвэр, шатахуун	2,397,000.00	1,734,505.00	662,495.00	72.4%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,991,100.00	3,615,538.00	(624,438.00)	120.9%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,195,000.00	300,000.00	895,000.00	25.1%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,484,100.00	648,000.00	3,836,100.00	14.5%
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>80,000,000.00</b>	<b>79,996,614.00</b>	<b>3,386.00</b>	<b>100.0%</b>
Урсгал засвар	80,000,000.00	79,996,614.00	3,386.00	100.0%
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>850,000.00</b>	<b>850,000.00</b>	<b>-</b>	<b>100.0%</b>
Дотоод албан томилолт	850,000.00	850,000.00	-	100.0%
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,335,300.00</b>	<b>1,490,700.00</b>	<b>6,844,600.00</b>	<b>17.9%</b>
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	995,400.00	995,400.00	-	100.0%
Даатгалын үйлчилгээ	499,700.00	429,300.00	70,400.00	85.9%
Тээврийн хэрэгслийн татвар	248,900.00	-	248,900.00	0.0%
Тээврийн хэрэгслийн оношлогоо	119,800.00	66,000.00	53,800.00	55.1%
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	996,600.00	-	996,600.00	0.0%
Газрын төлбөр	5,474,900.00	-	5,474,900.00	0.0%
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>94,217,600.00</b>	<b>86,772,137.00</b>	<b>7,445,463.00</b>	<b>92.1%</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	94,217,600.00	86,772,137.00	7,445,463.00	92.1%
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>116,776,500.00</b>	<b>16,163,000.00</b>	<b>100,613,500.00</b>	<b>13.8%</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>116,776,500.00</b>	<b>16,163,000.00</b>	<b>100,613,500.00</b>	<b>13.8%</b>
Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	115,996,500.00	15,383,000.00	100,613,500.00	13.3%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	780,000.00	780,000.00	-	100.0%
Төсвийн байгууллага	1	1	-	100.0%
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>33</b>	<b>33</b>	<b>-</b>	<b>100.0%</b>
Удирдах ажилтан	1	1	-	100.0%
Гүйцэтгэх ажилтан	20	20	-	100.0%
Үйлчлэх ажилтан	12	12	-	100.0%

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>511,950,795.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>511,950,795.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>502,230,795.00</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>19,781,514.00</b>
210102	Нэмэгдэл	19,781,514.00

**Баянхонгор аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	431,494,281.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	431,494,281.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	50,955,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,750,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,205,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	9,720,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	9,720,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,720,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	511,950,795.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	511,950,795.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	503,950,795.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,000,000.00

**ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 11,291.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 11,291.0 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Сангийн сайдын 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 47 дугаар тушаалаар тухайн байгууллагын 2025 оны жилийн эцсийн зарцуулагдаагүй улсын төсөвт төвлөрүүлсэн дансны үлдэгдлээс 10,364.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгахаар шийдвэр гарсан байхад авлагаар тусгаагүй байна.
2. Нэмэлт санхүүжилтийн Төрийн сан дахь 100030035401 тоот дансанд 927.0 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байхад санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Эдгээр нь УСНББОУС1-Санхүүгийн тайлангийн толилуулга, Ангилал болон Иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 125,480.3 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 20,425.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 85,174.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 19,881.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 125,480.3 мянган төгрөгийн алдаа, зөрчлөөс 20,425.0 мянган төгрөгийн материаллаг залруулагдаагүй алдаа болон зөрчил гэж тооцсон ба бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,731.1 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

**3.1 Төлбөрийн акт**

1. Тухай байгууллагын төсөвт халаалтын төсвийг 7 сараар тооцож төсөвлөсөн байхад 7 багийн төвийн спортын заалны халаалтын зардлыг 8 сараар тооцож Хөвших Од ХХК- руу 12,257.0 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Батлагдсан төсөв хэтрүүлэн зарцуулсан 12,257.0 мянган төгрөгийг "Хөвших Од" ХХК-ны 2026 оны халаалтын зардлаас суутган тооцож орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Баялаг дулаан ХХК 2025 оны 02 сарын 03-ны өдрөөс, Зүүн шанд ХХК, ФЮМ ХХК, Хөвших Од ХХК 2025 оны 01 сарын 08-ны өдрөөс эхлэн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тогтоосон үнийг мөрдөх байтал 2025 оны 1 сарын 1-нээс эхлэн мөрдсөнөөс шалтгаалж багуудын төвүүдийн спорт заалны халаалтын төлбөрт 7,128.3 мянган төгрөгийг илүү төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2024 оны 12 дугаар 13-ны өдрийн 50, 51, 57 дугаар тогтоол, 2025 оны 01 дүгээр 20-ны өдрийн 3, 7 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Халаалтын үнийг тарифыг мөрдөөгүйгээс илүү зарцуулсан 7,128.3 мянган төгрөгийг Зүүн шанд ХХК, ФЮМ ХХК, Хөвших Од ХХК-ны 2026 оны халаалтын зардлаас суутган тооцож орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### **3.2 Албан шаардлага**

1. Тайлант оны жилийн эцсийн байдлаар ашиглалтын хугацаа дууссан 72 нэр төрлийн 203 ширхэг 85,174.3 мянган төгрөгийн хөрөнгө байгаа бөгөөд тухайн хөрөнгийг дахин үнэлгээ хийх болон актлах асуудлыг шийдвэрлээгүй байна

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ашиглалтын хугацаа дууссан 72 нэр төрлийн 203 ширхэг 85,174.3 мянган төгрөгийн хөрөнгийг актлах болон дахин үнэлэх саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх албан шаардлага хүргүүлэв.

2. Тухай байгууллагын биет бус хөрөнгөд 12 төрлийн 62,996 м<sup>2</sup> газар бүртгэлтэй, газрын гэрчилгээ болон цахим санд (egazar.gov.mn)-д 59,062 м<sup>2</sup>, 11 төрлийн газар бүртгэлтэй байгаа бөгөөд 3,934 м<sup>2</sup> газар байгууллагын нэр дээр бүртгэгдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", УСОУНББ 17 – Үндсэн хөрөнгө 17.12-т Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана", Санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "Орших байх" гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын нэр дээр бүртгэлгүй байгаа газрыг бүртгүүлж зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

3. Биеийн тамир спортын газрын даргын 2025 оны 04 дүгээр 10-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар ёс хорооны 5 гишүүдэд цалингийн 20 хувь болох 1,039.8 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө.", 10 дугаар зүйлийн 10.2 дахь "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдад үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохгүй байх, Төрийн хэмнэлтийн хуулийг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Өмч хамгаалах зөвлөлтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Тус байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь ажлын төлөвлөгөө гаргаж батлуулаагүй ба хийсэн ажлын тайлан байхгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолоор батлагдсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 2.4-т "Өмч хамгаалах зөвлөл нь ажлын төлөвлөгөөг энэхүү журмын 1 дүгээр хавсралтад заасан загварын дагуу боловсруулж жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны өдөрт багтаан хуулийн этгээдийн удирдлагаар батлуулж ажиллана." 3 дугаар зүйлийн 3.3-т "Өмч хамгаалах зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, акталж, данснаас хасах зэрэг эд хөрөнгийн зохицуулалт, төрийн өмчийн үр ашгийг дээшлүүлэх асуудлыг судалж, дараах байдлаар зөвлөмж дүгнэлт гаргана." Гэсэн заалтыг зөрчсөн байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

Тус байгууллагын өмч хамгаалах зөвлөлийг журмын дагуу ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

#### **2. Зардлын данстай холбоотой асуудал**

#### **Илрүүлэлт:**

Тус байгууллагын дасгалжуулагч нарт тамирчдаа тэмцээн, уралдаанд авч явахад нь 19,881.0 мянган төгрөгийн урьдчилгаа олгосон боловч мөнгөн кассын журмын дагуу нярав кассын тайлан бэлтгэн гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т ".Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу зориулалтын картын данстай болох, кассын тайланг дасгуулагч уралдаан тэмцээнээс ирсэн дариуд гаргуулж нягтлан бодогч тооцоог бодож байх зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----

**ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Улсын төсөвт төвлөрүүлсэн дансны үлдэгдлээс 10,364.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгахаар шийдвэр гарсан байхад авлагаар тусгаагүй байна.	1	10,364.0	1	10,364.0			1	10,364.0				
Нэмэлт санхүүжилтийн Төрийн сан дахь 100030035401 тоот дансанд 927.0 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байхад санхүүгийн тайланд тусгаагүй байна.	1	927.0	1	927.0			1	927.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>11,291.0</b>	<b>2</b>	<b>11,291.0</b>			<b>2</b>	<b>11,291.0</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тухай байгууллагын төсөвт халаалтын төсвийг 7 сараар тооцож төсөвлөсөн байхад 7 багийн төвийн спортын заалны халаалтын зардлыг 8 сараар тооцож Хөвших Од ХХК руу 12,257.0 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байна	1	12,257.0	1	12,257.0				
Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тогтоосон үнэ тарифыг мөрдөж эхлэх хугацааг мөрдөөгүйгээс 7,128.3 мянган төгрөгийг илүү төлсөн байна.	1	7,128.3	1	7,128.3				
Тайлант оны жилийн эцсийн байдлаар ашиглалтын хугацаа дууссан 72 нэр төрлийн 203 ширхэг 85,174.3 мянган төгрөгийн хөрөнгө байгаа бөгөөд тухайн хөрөнгийг дахин үнэлгээ хийх болон актлах асуудлыг шийдвэрлээгүй байна	1	85,174.3			1	85,174.3		
Байгууллагын биет бус хөрөнгөнд 3,934 м2 газар бүртгэлтэй боловч байгууллагын нэр дээр бүртгэгдээгүй байна	1	0			1	0		
Тус байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь ажлын төлөвлөгөө гаргаж батлуулаагүй ба хийсэн ажлын тайлан байхгүй байна.	1	0					1	0
Тус байгууллагын дасгалжуулагч нар тамирчдаа тэмцээн, уралдаанд явахдаа дасгуулагч нарын данс руу урьдчилан тайлант онд 19,881.0 мянган төгрөгийг шилжүүлсэн ба нярав кассын тайлан гаргахгүй байна.	1	19,881.0					1	19,881.0
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>124,440.6</b>	<b>2</b>	<b>19,385.3</b>	<b>2</b>	<b>85,174.3</b>	<b>2</b>	<b>19,881.0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Биеийн тамир спортын газрын даргын 2025 оны 04 дүгээр 10-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар ёс хорооны 5 гишүүдэд цалингийн 20 хувь болох 1,039.8 мянган төгрөгийг олгосон байна	1	1,039.8	1	1,039.8		
Дүн	1	1,039.8	1	1,039.8		

-----oOo-----